



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХЛАНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2022 онд 06 сарын 15 одор

Дугаар A/214

Уланбаатар хот

Чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд суралцагчийг үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгасугай.

2.1. Чиглэлийг сургалтын байгууллагад хүргүүлэх, хэрэгжүүлэхэд удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлэхийг Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/-т;

2.2. Сургуулийн орчинд үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалт гаргахгүй байх, энэ талаарх серөг үйл ажиллагааг таслан зогсоож, суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон олон нийтэд зориулсан зэрэг нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, хэвшүүлэхийг ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт.

3. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг жил бүрийн 6 дугаар сард багтаан танилцуулахыг Боловсролын ерөнхий газрын дарга /Т.Ням-Очир/-д даалгасугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН



142210775

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2022 оны 06 дугаар сарын 15-ны  
өдрийн 16:14 дугаар тушаалын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРЫН ОРЧИНД  
СУРАЛЦАГЧИЙГ ҮЕ ТЭНГИЙНХНИЙ ДАРАМТ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТАД  
ӨРТӨХӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Хүүхдийг ивээх сан /Япон/-ийн Монгол дахь хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 11-16 насны 1236 суралцагчийг хамарсан судалгааны үр дүнгээр судалгаанд оролцогчдын 37,9 хувь нь ямар нэг байдлаар дээрэлхүүлж, доромжуулсан, 40,7 хувь нь бусад хүүхдийг зодуулж дээрэлхүүлж байхыг харсан, 80 гаруй хувь нь дарамтуулж, шоовдорлуулсан, ямар нэг асуудал гарахад хаана хандахаа мэддэггүй гэж тус тус хариулсан байна.

Ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн ирээдүйн сайн сайханд хэрэгтэй олон үр чадвар эзэмшүүлдэг, эрүүл, аюулгүй, хүртээмжтэй орчин байхаас гадна хүүхдийг нас, хүйс, арьс өнгө, шашин шүтлэг, хөгжлийн онцлогоор ялгаварлан гадуурхдаггүй, үе тэнгийнхний дарамтад өртүүлэхгүй байх орчин байх ёстой.

Сургуулийн орчинд хүүхдэд ээлтэй орчин, нөхцөл бүрдүүлэхэд аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх нэгдсэн арга зүй хэрэгтэй байна.

Иймд суралцагчийг сургууль, дотуур байрын орчинд дарамтанд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хянах, хамгаалахад эцэг эх, асран хамгаалагч, сургууль, суралцагчийн оролцоо, хамтын ажиллагаа нэн чухал байна.

**Хоёр. Зорилго**

Ерөнхий боловсролын сургууль /цаашид "сургууль" гэх/, дотуур байрын орчинд суралцагчийг үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах мэргэжлийн үйлчилгээг багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн дэмжлэгтэйгээр үзүүлж, суралцагч аливаа хэлбэрийн дарамтгүй, аюулгүй суралцах нийгэм-сэтгэлзүйн орчин бүрдүүлэхэд энэхүү чиглэлийн зорилго оршино.

Энэ чиглэлийг хэрэгжүүлэхэд хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн хамтын оролцоонд суурилах, сайн дурын санаачилга, үйл ажиллагааг дэмжих, хичээл заах, анги удирдах, хүүхэдтэй ажиллах алхам бүрд багш, ажилтан мэргэжлийн ёс зүйг баримтлах, хүмүүжлийн зэрэг арга хандлагыг хэрэглэх зарчим баримтална.

**Гурав. Үйл ажиллагааны чиглэл**

1. Сургууль, дотуур байрын орчинд суралцагч бүрийг үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс сэргийлэх, аюулгүй суралцаж хөгжих орчин, нөхцөлийг бүрдүүлэх;
2. Мэдээлэл хүлээн авах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх;
3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

## Дөрөв. Чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээ

Чиглэл 1. Сургууль, дотуур байранд суралцагч бүрийг үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлэх

4.1. Сургуулийн дүрэм, журам болон байгууллагын соёлд үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх агуулгыг тусгах, хэрэгжүүлэх, хяналт тавих

4.1.1. Сургуулийн дүрэм, дотоод журамд үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, сургуульд зерэг уур амьсгал бүрдүүлэхэд чиглэсэн агуулгыг тусгаж, хэрэгжилтэд хянах тавих;

4.1.2. Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаанд мөрдөх дэгийг суралцагчийн оролцоотой боловсруулж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.

4.2. Багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдад үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтын талаар ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх

4.2.1. Үе тэнгийнхний дарамтын мөн чанар, шалтгаан, үр дагавар, илрэх хэлбэр, дарамт, ялгаварлан гадуурхалт бий болох тохиолдолд үзүүлэх хариу үйлчилгээ, бусдад хэрхэн мэдээлэх талаар багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, үр дүнг тайлагнах;

4.2.2. Үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаа, сайн туршлага хуваалцах, харилцан суралцах арга хэмжээг сургууль, орон нутгийн түвшинд зохион байгуулах;

4.2.3. Сургуулийн орчинд байгаа аливаа хэлбэрийн дарамтлах үйлдлийг зогсооход боловсролын харилцаанд оролцогч тал (удирдах болон бусад ажилтан, багш, суралцагч) өөрөөсөө өхөлж, бусдын онцлогийг хүлээн зөвшөөрөх, ялгаварлахгүй, адил, тэгш хундэтгэлтэй хандах, хувь хүний мэдээллийг чанд хамгаалах, харилцан итгэлцлийг бий болгоход чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах;

4.2.4. Эерэг байдал, нээлттэй байдал, дэмжлэгт суурисан сургалтын орчныг бүрдүүлэхтэй холбогдуулан сургуулийн соёлд тулгарч буй асуудлын талаар нээлттэй ярилцаж, зөвлөлдөх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд бүх талын оролцоог хангах, ил тод нээлттэй байх асуудлыг хэвшүүлэх;

4.2.5. Үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд суралцагчдын идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэхэд үе тэнгийн сургач хүүхэд бэлтгэх, сурагчдын оролцооны байгууллагатай хамтарч нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах.

4.3. Сургууль дахь үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтын нөхцөл байдлыг тогтмол үнэлэх, "эрсдэлтэй газрууд"-ад насанд хүрэгчийн хараа, хяналтыг сайжруулж, олон нийтийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх

4.3.1. Сургууль бүр хичээлийн жилийн эхэнд өөрийн сургуулийн суралцагчдын дунд үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтын тохиолдол, илрэх хэлбэр, цар хүрээний талаар үнэлгээ хийх, сургууль, суралцагчийн хандлагыг үнэлэх;

4.3.2. Үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтын тохиолдлыг давтамж, хор уршиг, хүндрэлийн түвшин зэрэг тодорхой шалгуур үзүүлэлтээр үнэлэн түвшин тогтоож, хариу арга хэмжээ авах;

- Маш хүнд түвшинд үнэлэгдсэн тохиолдлыг холбогдох байгууллага, үйлчилгээнд шилжүүлж хамтран шийдвэрлэх;

- Хүнд түвшний тохиолдолд сургуулийн хүүхэд хамгааллын багаар ажиллаж шийдвэрлэх, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах;
- Дундаж түвшний тохиолдолд сургуулийн хүүхэд хамгааллын багаар хэлэлцэн, дарамталсан суралцагчид сануулах, эцэг эх, асран хамгаалагчид сануулах, дарамталсан ба дарамтад өртсөн суралцагчид сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, ганцаарчилсан болон бүлгийн сургалт зохион байгуулах гэх мэт арга зүйгээр ажиллаж, дарамтын тохиолдол дахин давтагдахаас сэргийлэх.

4.3.3. Сургуулийн орчинд тохиолдсон үе тэнгийнхний дарамтын тохиолдлууд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн, үр дүнтэй эсэх, алдаа дутагдал, сургамж зэргийг тодорхойлоход чиглэсэн нарийвчилсан чанарын шинжилгээ хийх (кейс шинжилгээ), үнэлгээг хичээлийн жилийн төгсгөл давтан хийж, хэвших;

4.3.4. Энэ чиглэлийн 4.3.1, 4.3.3-д заасан үнэлгээтэй харьцуулах, үр дүнг мэдээлэх ажлыг хийх, хэвших;

4.3.5. Үнэлгээгээр үе тэнгийнхний дарамт ихэвчлэн тохиолддог газар буюу "эрсдэлтэй газрууд"-ыг илрүүлж, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчийн хараа, хяналтыг нэмэгдүүлэх, манлайллыг бий болгох;

4.3.6. Сургууль, дотуур байрын орчинд үе тэнгийнхний дарамт гарч болзошгүй объект (харанхуй булан, гэрэлтүүлэг муутай газар, хараа хяналтгүй шат, угаалгын болон ариун цэврийн өрөө, байгууламж)-д тавих багш, ажилтны хараа хяналтыг нэмэгдүүлэх;

4.3.7. Үе тэнгийнхний дарамтын хандлага нэмэгддэг газар болон цагт анхаарлаа хандуулах, байнгын хяналт тавих.

4.4. Дотуур байр, ангийн ажлын тодорхой нэг хэсгийг үе тэнгийнхний дарамт, ялгааарлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэхэд зориулах, суралцагчид тохирсон, тэдний оролцоог хангасан үйл ажиллагааг санаачлан, хэрэгжүүлэх

4.4.1. Үе тэнгийнхний дарамт, ялгааарлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг анги болон дотуур байранд үр дүнтэй зохион байгуулах, суралцагч хоорондын харилцааг сайжруулах гэсэн үйл ажиллагааны нэгдэл байхад анхаарч, үйл ажиллагаа төлөвлөх, зохион байгуулах /бусадтай мэндэлж хүндлэх, бусдад тусалж, талархах соёл, ахан дүүсийн ёс, үл алагчлах, хүчээр бус ухаанаар шийдэх/;

4.4.2. Дотуур байрын хүүхэд болон ангийн хамт олонч уур амьсгалыг бурдүүлэх, зорилтот бүлгийг суралцагчийг хэвийн байдалдаа эргэн ороход туслахад чиглэсэн суралцагчийн оролцоонд тулгуурласан сургалт, үйл ажиллагааг уян хатан, арга, хэлбэрээр зохион байгуулах;

4.4.3. Анги удирдсан болон дотуур байрын багш нь өөрийн удирдсан ангийн суралцагчид, дотуур байранд амьдарч буй хүүхдийн дунд гарч болох аливаа хэлбэрийн зөрчилдөөн, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хичээлийн жилийн эхэнд төлөвлөх, хэрэгжүүлэх, үе тэнгийнхний дарамт, ялгааарлан гадуурхалтыг бууруулахад чиглэсэн ангийн уур амьсгалыг зерэг болгоход бодитой хувь нэмэр оруулах;

4.4.4. Суралцагчид бусдыг хүндлэх, өрөвдөх хайрлах нинжин сэтгэл, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, жендерийн мэдрэмжтэй байх, өөрийгөө бусдын оронд тавих чадвар, сэтгэл хөдлөлөө хянах, удирдах зэрэг ур чадварыг хичээл, хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаагаар олгох;

4.4.5. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа, секц, дугуйлан, клуб, сурагчдын оролцооны байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, сургалт, хэлэлцүүлэг, мэтгэлцээн

зэрэг соён гэгээрүүлэх нөлөөлийн арга хэмжээг суралцагчийн оролцоотой мэргэжлийн багшийн удирдлага дор анги, танхим, хүний нөөц, техник технологийн боломжид тулгуурлан зохион байгуулах.

## **Чиглэл 2. Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх**

4.5.1. Сургуулийн орчинд тохиолдож буй үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтын талаарх мэдээлэл хүлээн авах тогтолцоог бүрдүүлэх;

4.5.2. Үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтын талаарх мэдээллийн дагуу ажиллахад мэдээллийн эх сурвалжийн аюулгүй байдлыг анхаарч, хувийн мэдээллийн нууцлалыг чанд хамгаалах;

4.5.3. Үе тэнгийнхний дарамтын талаар мэдээллийн дагуу сургуулийн хүүхэд хамгааллын баг хэрхэн ажиллах заавар боловсруулж, мөрдөх, үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтын талаар хэрхэн мэдээлэх, шийдвэрлэх зураглалыг боловсруулж, ил тод байршуулах;

4.5.4. Дарамт, ялгаварлан гадуурхалтын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх үйл явцад эцэг эх, асран хамгаалагчийг хязгаарлагдмал хүрээнд буюу мэдээлэл хүлээн авах, шаардлагатай мэдээллээр хангах замаар оролцуулах;

4.5.5. Үе тэнгийнхний дарамтын тохиолдол мэдэгдэж, шаардагдах арга хэмжээ авсан даруйд тухайн тохиолдолтой ижил төрлийн дарамт, ялгаварлан гадуурхалт дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.5.6. Үнэлгээнд суурилан дарамт, ялгаварлан гадуурхалтад өртсөн суралцагчийг хамгаалах, хамтран хэрэгжүүлэх аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулах, холбогдох арга хэмжээг авах.

## **Чиглэл 3. Үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**

4.6.1. Сургууль, дотуур байрын болон суралцагчийн уур амьсгалыг үнэлэх үнэлгээг сургуулийн захирал, , нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, дотуур байрын багш хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын төлөөлөл, эцэг эхийн зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн баг хийх бөгөөд хүүхдийг болзошгүй эрсдэлд хүргэх өндөр эрсдэлтэй газар, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.

4.6.2. Энэхүү чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээг аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс харьяа нутаг дэвсгэрийн өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль, дотуур байрыг бүрэн хамруулж эцэг эхийн зөвлөлтэй хамтран жил бүр хийж, тайланг жил бүрийн 06 дугаар сарын 10-ны дотор Боловсролын ерөнхий газарт хүргүүлнэ.

4.6.3. Боловсролын ерөнхий газар энэ чиглэлийн 4.6.2-т заасан үнэлгээний тайланд шинжилгээ хийж, ерөнхий боловсролын сургуулиудад зөвлөмж өгч ажиллана.